



Нэгдсэн Үндэстний
боловсрол, шинжлэх ухаан,
соёлын байгууллага

United Nations
Educational, Scientific and
Cultural Organization

Организация
Объединённых Наций по
вопросам образования,
науки и культуры

ЮНЕСКО-ийн ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ ХАТАГТАЙ ИРИНА БОКОВАГААС ДЭЛХИЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ӨДӨРТ ЯВУУЛСАН ИЛГЭЭЛТ

2010 оны 5 дугаар сарын 3-ны өдөр

“Мэдээллийн эрх чөлөө” сэдэвтэй Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр нь бид бүхний мэдэх эрхийн ач холбогдлыг эргэн санах боломж олгодог.

Мэдээллийн эрх чөлөө нь олон нийтийн мэдээлэл хүртэх эрхийн дагуу Засгийн газар болон төрийн байгууллагуудын мэдээллийг ил тод болгож, иргэдэд мэдээлэл чөлөөтэй авах боломж олгохтой уялддаг зарчим билээ.

Мэдээллээр хангагдах эрх нь бусад үндсэн эрхүүд болон шударга ёс, хөгжил дэвшилд дэмжлэг үзүүлэх суурь ач холбогдолтой юм. Түүний салшгүй хэсэг болох үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх гэдэг нь ардчиллын суурь ойлголт юм.

Бид мэдээллээр хангагдах эрхээ санамсаргүйгээр ч гэсэн эдэлж болдог. Гэвч, мэдээ сонсох, сонин унших, зурагт үзэх, радио асаах эсвэл интернэтэд холбогдох бүрт бидний үзэж, сонсож буй зүйлийн чанар нь эдгээр хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн үнэн зөв, шуурхай мэдээлэл түгээж буй эсэхээс шалтгаалдаг.

Бидэнд мэдээллийн эрх чөлөөгөө эдлэхэд зохистой дэд бүтэц байхгүйгээс эхлээд эх сурвалжийн хомсдол, мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах явдал хүртэл төрөл бүрийн саад тотгор тохиолддог.

Олон сэтгүүлч мэргэжлийн ажлаа эрхлэх явцдаа мэдээллийн хувьд хязгаарлагдмал нөхцөлд ажиллах нь хэвийн үзэгдэл болж, өдөр тутмынхаа үйл ажиллагаанд дарамт шахалт, мөрдөлт, айлган сүрдүүлэлт, бие махбодийн хүчирхийлэлд өртдөг байна.

НҮБ өнгөрсөн жил 77 сэтгүүлчийн амь насыг бүрэлгэсэн хэргийг хэлэлцжээ. Тэдний ихэнх нь дайн тулааны талбарт амь үрэгдсэн бус, орон нутгийн амьдралыг соён гэгээрүүлж байсан нутгийн сурвалжлагчид байв.

Би дэлхийн хэвлэл мэдээллийн эрх чөлөөний өдрийг тэмдэглэж буй хүн бүхэнд бидний мэдээллээр хангагдах эрх чөлөөний төлөө амь насаа зориулсан тэдгээр сэтгүүлчдийн гэгээн дурсгалыг хүндэтгэж, нэг минут дуугүй зогсохыг уриалж байна.

Гэсэн ч өнөөдөр олж авсан үлэмж дэвшилээ ч мөн хүлээн зөвшөөрцгөөе.

Дэлхий дээр улам олон улс орон мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг баталж байна. Энэ нь төр, засгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хөнгөвчилж, улсын хариуцлагатай байдлыг бататгаж байна.

Үүнээс гадна хурдан, хямд технологи нь өнөөдөр дэлхий дээр урьд өмнөөс илүү олон хүн өдөр тутмын амьдралаасаа гадуурх үйл явдлын мэдээллийг чөлөөтэй хүртэх болсныг харуулж байна.

Бид байгууллагуудыг бэхжүүлэх, хэвлэл мэдээллийн ажилтнуудыг бэлтгэх, төрийн байгууллагуудыг нээлттэй, ил тод болгоход нөлөөлж, нийгмийн мэдээллээр хангагдах түвшинг дээшлүүлэхэд энэхүү дэвшлийг ашиглах хэрэгтэй байна.

Би, төр засаг, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бүх хүмүүсийг мэдээллийн эрх чөлөөнд дэлхий даяар дэмжлэг үзүүлэх үйл хэрэгт ЮНЕСКО-той хүчээ нэгтгэхийг уриалж байна.

Ирина Бокова